

**ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ  
“ЦАГААН ЧУЛУУТЫН ХООЛОЙН ДУНД ХЭСЭГ ” НЭРТЭЙ АЛТНЫ  
ШОРООН ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

*Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-003108  
Регистрийн дугаар: 2763788*

**Хянасан:**

БОУАӨЯ-ны ХБОБНУГазрын мэргэжилтэн: .....

Дорнод аймгийн БОГазрын мэргэжилтэн: .....

**Биелэлтийг тайлагнасан:**

“ХОТУ” ХХК-ний захирал: ..... Ц.Түвшинжаргал

Байгаль орчны мэргэжилтэн: .....Э.Мөнгөнтуяа



## Агуулга

1. ОРШИЛ.....	5
2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	6
3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	11
3.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ .....	11
3.2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ .....	14
3.3. Газрын хэвлийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт .....	17
3.4. Ургамал, амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах аргууд .....	21
4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	22
5. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	28
6. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	29
7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	29
8. ХИМИЙН БОДИС, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	29
9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	29
10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ .....	33
11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	35
12. ДҮГНЭЛТ .....	38

**Зургийн жагсаалт**

Зураг № 1 Талбайн байршил <span></span> ын тойм зураг .....	6
Зураг № 2 Уурхайн олборлолтын явц .....	7
Зураг № 3 Уурхайн кемп .....	9
Зураг № 4 Уурхайн кемп .....	10
Зураг № 5 Ажилчдын хоолны газар .....	10
Зураг № 6 Зам усалгааны ажил хийгдэж буй байдал .....	12
Зураг № 7 Уурхайн ажилчдын кемпэд тоосжилтын хэмжилт хийж буй байдал.....	12
Зураг № 8 Уурхайн тээврийн замд агаарын хэмжилт хийж буй байдал.....	13
Зураг № 9 Хурдны хязгаарын тэмдгүүд.....	14
Зураг № 10 Үерийн ус болон галын аюулаас хамгаалах даланг байгуулсан байдал.....	15
Зураг № 11 Цэврийн нуураас дээж авч буй байдал .....	16
Зураг № 12 Бохирын нуураас дээж авч буй байдал.....	16
Зураг № 13 Кемпээс ундны усны дээж авч буй байдал.....	17
Зураг № 14 Уурхайн шүүрлийн уснаас дээж авч буй байдал.....	17
Зураг № 15 Шимт хөрснөөс дээж авч буй байдал.....	18
Зураг № 16 ШТС талбай.....	19
Зураг № 17 ШТС-ын талбайгаас хөрсний дээж авч буй байдал.....	19
Зураг № 18 Засварын талбай.....	20
Зураг № 19 Засварын талбайгаас хөрсний дээж авч буй байдал.....	20
Зураг № 20 Галын сарааг ШТС талбайд байршуулсан байдал, уурхайн техник бүрд галын аюулгүй байдлыг хангаж буй байдал .....	21
Зураг № 21 Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн байршил .....	23
Зураг № 22 Дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийж буй байдал .....	24
Зураг № 23 Техникийн нөхөн сэргээлт хийж буй байдал 2025 .....	24
Зураг № 24 Үрийн холимгоо бэлтгэх, трактороор үрслэгээний ажил хийж буй байдал.....	25
Зураг № 25 Биологийн нөхөн сэргээлтийн ургалт 2025.09.05 .....	25
Зураг № 26 Биологийн нөхөн сэргээлтийн ургалт 2025.09.17 .....	26
Зураг № 27 Хог хаягдлаа ангилан ялгах тусгай талбай байгуулсан байдал.....	31
Зураг № 28 Хаягдал тосыг цуглуулж буй байдал .....	31
Зураг № 29 Сумын хогийн цэгт ахуйн хог хаягдлаа хаяж буй байдал .....	32
Зураг № 30 Ахуйн бохир цэвэрлэх байгууламж суурьлуулж байгаа байдал .....	32
Зураг № 31 Ажилчдад зориулсан халуун ус, дотор нойл бүхий ариун цэврийн газрын тохижилт .....	33
Зураг № 32 Иргэдэд хийсэн ажлаа танилцуулж буй байдал.....	37

**Хүснэгтийн жагсаалт**

Хүснэгт 1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт	11
Хүснэгт 2 Уурхайн агаарын хэмжилтийн дүн .....	13
Хүснэгт 3 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт.....	15
Хүснэгт 4 Газрын хэвлийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт .....	18
Хүснэгт 5 Ургамал амьтны сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт .....	21
Хүснэгт 6 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө болон биелэлт .....	29
Хүснэгт 7 Орчны хяналт шинжилгээний хүрээнд хийгдсэн ажил .....	35
Хүснэгт 8 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө болон биелэлт.....	36
Хүснэгт 9 Нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн ажлын жагсаалт.....	37
Хүснэгт 10 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....	37

*Хавсралт материалын жагсаалт*

<i>Хавсралт № 1 Шимт хөрсний дээжийн хариу.....</i>	<i>40</i>
<i>Хавсралт № 2 ШТС болон засварын талбайн хөрсний хүнд металлын шинжилгээний дүн.....</i>	<i>46</i>
<i>Хавсралт № 3 Цэвэр, бохир нуурын усны химийн шинжилгээний дүн .....</i>	<i>47</i>
<i>Хавсралт № 4 Бохирын нуурын усны хүнд металлын шинжилгээний дүн.....</i>	<i>57</i>
<i>Хавсралт № 5 Ундны усны бактерлогийн шинжилгээний дүн .....</i>	<i>58</i>
<i>Хавсралт № 6 Ундны усны химийн шинжилгээний дүн.....</i>	<i>59</i>
<i>Хавсралт № 7 Сав газрын даргын тушаал.....</i>	<i>60</i>
<i>Хавсралт № 8 Ус ашиглах гэрээ.....</i>	<i>64</i>
<i>Хавсралт № 9 Ус ашиглуулах дүгнэлт.....</i>	<i>68</i>
<i>Хавсралт № 10 Ахуйн ус ашиглах гэрээ .....</i>	<i>69</i>
<i>Хавсралт № 11 Тоолуурын баталгаажуулалтын гэрчилгээ .....</i>	<i>70</i>
<i>Хавсралт № 12 Унд ахуйн усны төлбөр төлсөн баримт .....</i>	<i>70</i>
<i>Хавсралт № 13 Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн ажлын тухай орон нутгийн бичиг.....</i>	<i>71</i>
<i>Хавсралт № 14 Хог хаягдал гэрээ.....</i>	<i>73</i>
<i>Хавсралт № 15 Хог хаягдлын төлбөр төлсөн баримт.....</i>	<i>74</i>
<i>Хавсралт № 16 Хог хаягдлын цэгт хог нийлүүлсэн ажлын акт .....</i>	<i>74</i>
<i>Хавсралт № 17 Байгаль орчны хяналт шинжилгээний тайлан.....</i>	<i>75</i>
<i>Хавсралт № 18 Аюултай хог хаягдал нийлүүлэх гэрээ .....</i>	<i>76</i>
<i>Хавсралт № 19 Аюултай хог хаягдлын төлбөр төлсөн баримт .....</i>	<i>77</i>
<i>Хавсралт № 20 Аюултай хог хаягдал тушаасан акт.....</i>	<i>78</i>
<i>Хавсралт № 21 Нөхөн сэргээлтийн тусгай зөвшөөрөл .....</i>	<i>79</i>
<i>Хавсралт № 22 Нөхөн сэргээлтийн барьцаа төлбөр төлсөн баримт .....</i>	<i>80</i>
<i>Хавсралт № 23 Газрын гэрчилгээ.....</i>	<i>81</i>
<i>Хавсралт № 24 Газрын төлбөр төлсөн баримт.....</i>	<i>82</i>
<i>Хавсралт № 25 Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн ажлын төлбөр төлсөн баримт .....</i>	<i>82</i>
<i>Хавсралт № 26 Дүйцүүлэн нөхөн сэргээлт хийх ажлын гэрээ.....</i>	<i>83</i>


## 1. ОРШИЛ

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан нь 2025 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөний заалтуудыг ханган ажиллахад чиглэсэн болно.

“Цагаан чулуут хоолойн дээд хэсэг” нэртэй 380.2га бүхий MV-003108 дугаартай ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг АМГТГ-ын Кадастарын хэлтсийн даргын 2016 оны 10-р сарын 10-ны өдрийн 51 тоот шийдвэрээр “ХОТУ”ХХК-д шилжүүлсэн байна. Цагаан чулуут хоолойн дунд хэсгийн алтны шороон ордын доод давхарга нь алттай дан давхаргаас бүрдэх ба харьцангуй бага уналтай тэгш маягийн U хэлбэрийн хөндийг дагаж тогтсон, аллювиаль-пролювиаль гаралтай голын сэвсгэр хурдсанд хуримтлагдсан, тууз хэлбэрийн энгийн тогтоцтой, III бүлгийн орд юм. Ордын ашигт давхарга суналын дагуу тогтоогдсон бөгөөд ерөнхийдөө тууз хэлбэрийн тогтоцтой алт агуулсан хурдас нь нийлмэл тогтоцтой, дунд зэрэг мөлгөржсөн, 700м урттай, дундаж өргөн 60м, дундаж гүн 21м байна. “ХОТУ”ХХК-ийн MV-003108 дугаартай ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайг компани хоорондын гэрээний үндсэн дээр олборлолтын үйл ажиллагааг “Юбиксолюшн”ХХК хариуцан гүйцэтгэж байгаа билээ. Тиймээс зарим байгаль орчны ажил болон төлбөрүүд олборлогч компанийн нэр дээр хийгдсэн болно.

## 2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Газар зүйн байршил: “Цагаан чулуут хоолойн дунд хэсэг” нэртэй MV-003108 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй судалгааны талбай нь засаг захиргааны хуваариар Монгол улсын зүүн хойд хэсэг, Дорнод аймгийн Баяндун сумын нутагт харьяалагдах бөгөөд улсын геодезийн нэгдсэн номинклатурын М-49-95, 96 хавтгайд байрлах бөгөөд Улаанбаатар хотоос 704 км, Баяндун сумаас хойд зүгт 35 орчим километрийн зайнд байрлана.



Зураг № 1 Талбайн байршлын тойм зураг



*Зураг № 2 Уурхайн олборлолтын явц*

### **2025 онд явагдах уулын ажил, ажиллах горим**

#### **✓ Ажиллах горим.**

Уурхай нь 2025 онд 3-р сарын 01-ээс бэлтгэл ажлыг эхлүүлж, 4-р сарын 1-ээс 9-р сарыг дуустал хөрс хуулах, элс олборлох, элс угаах, нөхөн сэргээлт хийх болон бусад ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үйлдвэрлэлийн үндсэн процессууд нь тасралтгүй 7 хоног, өдөрт 2 ээлжээр 12 цагийн уртасгасан хугацаагаар явагдана. Үйлдвэрлэлийн бусад ажил болох цахилгаан хангамж, усан хангамж, гэрэлтүүлэг, усан сан байгуулах болон угаан баяжуулах тоног төхөөрөмж угсарч монтажлах ажлуудыг үйлдвэрлэлийн дотоод ажлын зохион байгуулалтаар хийхээр төлөвлөсөн.

### **2025 онд явагдах уулын ажил.**

2025 оны 3-р сард уурхайн бэлтгэл ажлыг хангаж, Цагаан чулуут хоолойн уурхайд манай компанид бэлэн байгаа техник, тоног төхөөрөмжүүдийг үргэлжлүүлэн ашиглах бөгөөд уулын ажлаар 32.54 мян.м3 алттай элсийг олборлон баяжуулах хүчин чадалтайгаар ажиллана.

#### **✓ Үржил шимт хөрс хуулалт.**

Үржил шимт хөрсийг хуулахдаа 0.3 м-ийн зузаантайгаар бульдозероор хуулан түрж техникийн нөхөн сэргээлт хийх үед ашиглах зорилгоор ил уурхайн олборлолтын талбайн гадна уурхайн ирмэг дагуулан түрж овоолно. Энэ нь дотоод овоолгоор техникийн нөхөн

сэргээлт хийсэн (ашигласан) блокуудыг үржил шимт хөрсөөр шууд хучиж дараа дараагийн нөхөн сэргээлтийн ажлын зардлыг хэмнэх давуу талтай юм.

✓ **Хөрс хуулалт, тээвэрлэлтийн ажил.**

Алт агуулсан элсний тогтоц тэгш тогтвортой, гүн бага зэрэг дотоод овоолгоор төлөвлөх таатай нөхцөл байгаа тул шимт хөрсийг түрж үүсэх карьер дагуу овоолж, ашиглагдсан хоосон орон зайг хөрсөөр нөхөн дүүргэлт хийж дотоод овоолго хийж, нөхөн сэргээлтийн ажлыг хамт хийнэ. Ил уурхайн хөрсийг олборлосон орон зайг дүүргэх зорилгоор дотоод овоолгод байршуулна. Хөрс тээвэрлэлтийн ажилд HOWO маркийн 50 тн даацтай автосамосвал ажиллах ба тээвэрлэлтийн дундаж зай 0.5 км байна.

✓ **Элс олборлолтын ажил.**

Ордын баяжуулах хэсгийн ажиллах горим нь манай орны улирлын шинж чанар, цаг агаар, уур амьсгал, ил уурхайн үндсэн техник тоног төхөөрөмжийн бүтээл, уурхайн жилийн хүчин чадал зэрэгтэй уялдаж ажиллана. Баяжуулах хэсэг 2025 онд 32.54 мян.м<sup>3</sup> элс баяжуулах ба дунджаар 130 хоног ажиллана. Нийт 595.05 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, дунджаар 462.2 мг/м<sup>3</sup> агуулгатай 32.54 мян.м<sup>3</sup> элс олборлон баяжуулж 11.42 кг алт /химийн цэврээр/ гарган борлуулахаар төлөвлөсөн.

✓ **Ус хангамж**

Байгаль орчныг хамгаалах, цэвэр усны нөөцийг хэмнэх зорилгоор уурхайн технологийн усан хангамжид хэрэглэгдэх усыг хуримтлуулж, цэвэршүүлэх замаар эргүүлэн ашиглана. Алт олборлож байгаа уурхайнуудын туршлага, үүсмэл нуурын шүүрэлт, усны ууршилт, алдагдал, ордын талбайтай зэргэлдээ олборлолт явуулж байгаа ордын нууруудын шүүрэлт зэргийг үндэслэн шаардагдах усны 15%-ийг цэвэр усаар сэлбэх ба 85%-ийг технологийн эргэлтийн усаар хангах боломжтой байна. Ордын элс нь хялбар угаагдах шинж чанартай учир 1 м<sup>3</sup> элс угаахад 2.11 м<sup>3</sup> ус хэрэглэхээр тооцоолов.

Угаах процесст зарцуулах цэвэр усны хэмжээ 2024 онд 15.25 мян.м<sup>3</sup> байна. Нийт зарцуулагдах усны 85%-ийг эргэлтэд оруулж 15%-ийг цэвэр усаар сэлбэнэ. Технологийн усыг эргэлтийн усан санд хуримтлуулан тунгааж, процесст эргүүлэн хэрэглэхээр төлөвлөсөн.

✓ **Засвар, техникийн үйлчилгээ ба агуулахын аж ахуй.**

Тус уурхайн тоног төхөөрөмжийн засвар, техникийн үйлчилгээний газар нь тоног төхөөрөмж авто тээврийн болон бусад тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангахын тулд шаардлагатай зарим нэг техникийн үйлчилгээ хийх, ашиглалт засварын хэрэгцээнд зориулсан материал, сэлбэг, тос, түлш зэргийг хүлээн авах, хадгалах, тавьж олгох зэрэг ажлыг гүйцэтгэдэг. Тоног төхөөрөмжийн их засвар, зарим нарийн төвөгтэй эд ангийг сэргээх, бүрэн солих зэрэг ажлыг засварын дагнасан газраар буюу тоног төхөөрөмжийг нийлүүлсэн газрын засварын газраар гүйцэтгүүлдэг. Засварын газар нь дараах бүрэлдэхүүнтэй байна.

✓ **Шатах тослох материалын агуулах.**

ШТМ хадгалахад зориулж 50тн-ын ган сав 3 ш, тос тосолгооны материалуудыг зориулалтын савтай нь хадгалан хэрэглэнэ. ШТМ-ын агуулахыг гал, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагын норм дүрмийн дагуу байрлуулан, зориулалтын тоноглолоор хангасан байна.

**Сэлбэг материалын агуулах.**

Уурхайн тоног төхөөрөмжийн тоо, бүтцээс хамааруулан сэлбэг материал хадгалахад сэлбэг материалын агуулах нь уурхайн хотхонд буюу засвар механикийн хэсгийн хажууд байн



*Зураг № 3 Уурхайн кемп*



*Зураг № 4 Уурхайн кемп*



*Зураг № 5 Ажилчдын хоолны газар*

### 3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“ХОТУ”ХХК нь байгалийн баялгийг ашиглаж, үйл ажиллагаа явуулж байгаагийн хувьд оршин буй нутгийн байгаль орчныг хамгаалахад үйл ажиллагааныхаа нэг хэсгийг чиглүүлэх үүрэгтэй.

*Хүснэгт 1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт*

№	Төлөвлөгөө	Хариуцах эзэн	Биелэлт
1.	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийнхээ төлбөрийг төлнө. Уулын ажилд хамрагдах тээврийн хэрэгслүүд байна.	Уурхайн дарга	Тээврийн хэрэгслийн төлбөр, татварыг бүрэн төлж ажилласан.
2.	Агаарын тоосжилтыг бууруулах зорилгоор дотоод тээврийн замыг болон биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайг тогтмол усалж байна. тогтмол усалж байна.	Уурхайн дарга	Автозам, биологи хийсэн талбайг тогтмол усан, засаж, тэгшилж ажилласан. Дотоод тээвэрлэлтийн замууддаа тэмдэг тэмдэглэгээ хийж байршуулсан.
3.	Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоох, бууруулахын тулд хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлнэ.	Захирал	Хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан агаарын шинжилгээг хийлгэсэн ба шинжилгээний дүнг хавсаргав.
4.	Замаас үүсэх тоосжилтыг бууруулах- хурдны хязгаарыг дагаж мөрдүүлнэ.	Уурхайн дарга	Хурдны хязгаарыг дагаж мөрдөх ажлыг ХАБ хариуцан мөрдүүлсэн. Хүчтэй шороон шуурганы үед ажлыг зогсоох хүртэл арга хэмжээ авч ажилласан.

ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЦАГААН ЧУЛУУТ  
ХООЛОЙН ДУНД ХЭСЭГ”-ЫН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН




*Зураг № 6 Зам усалгааны ажил хийгдэж буй байдал*



*Зураг № 7 Уурхайн ажилчдын кемпэд тоосжилтын хэмжилт хийж буй байдал*

**ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЦАГААН ЧУЛУУТ  
ХООЛОЙН ДУНД ХЭСЭГ”-ЫН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**



*Зураг № 8 Уурхайн тээврийн замд агаарын хэмжилт хийж буй байдал*

*Хүснэгт 2 Уурхайн агаарын хэмжилтийн дүн*

№	Байршил	Сар өдөр	Хүхэрлэг хий /SO <sub>2</sub> / мг/м <sup>3</sup>	Азотын хий /NO <sub>2</sub> / мг/м <sup>3</sup>	Тоосны агууламж PM10 мг/м <sup>3</sup>	Дуу чимээ /ДБА/	Чийгшил
1.	Уурхай хотхон	IV/28	0.027	0.040	8	35	
2.	Карьер	IV/28	0.025	0.038	10	30	max42.4% min17.4%
3.	Тээвэрлэлтийн зам	IV/28	0.050	0.038	20	40	
	<b>MNS 4585:2025 стандарт</b>	-	<b>0.450</b>	<b>0.200</b>	<b>50</b>	<b>60.0</b>	40-60%



*Зураг № 9 Хурдны хязгаарын тэмдгүүд*

*3.1. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ*

Усны нөөцийг хамгаалах үүднээс технологит ашиглах усны хэмжээг бага байлгах үүднээс анхаарч ажилласан. Баяжуулах буюу элстэй шороог угаахад хэрэглэж буй усыг 15%-ийг сэлбэн 85%-ийг эргүүлэн ашигласан.

**ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЦАГААН ЧУЛУУТ  
ХООЛОЙН ДУНД ХЭСЭГ”-ЫН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**


*Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт*

*Хүснэгт 3 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт*

<b>№</b>	<b>Төлөвлөгөө</b>	<b>Хариуцах эзэн</b>	<b>Биелэлт</b>
1.	Сав газартай гэрээ байгуулан ус ашиглах дүгнэлт гаргуулах	Компанийн захирал	Сав газартай байгуулсан гэрээ болон ус ашиглах дүгнэлтийг хавсаргав.
2.	Уурхайгаа тойруулан үерийн далан байгуулах	Уурхайн дарга	Үерийн далан байгуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Хийсэн ажлын зураг оруулав.
3.	Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэх	Компанийн захирал	Ундны усанд химийн болон бактерлогийн шинжилгээ, технологийн нуурын усанд бохир усны хими болон хүнд металлын шинжилгээг “Нарт шуун консалтинг”ХХК, SGS -ийн лабораторид тус тус шинжлүүлсэн. Шинжилгээний хариуг хавсралтад оруулав.




*Зураг № 10 Үерийн ус болон галын аюулаас хамгаалах даланг байгуулсан байдал*



*Зураг № 11 Цэврийн нуураас дээж авч буй байдал*



*Зураг № 12 Бохирын нуураас дээж авч буй байдал*



*Зураг № 13 Кемпээс ундны усны дээж авч буй байдал*



*Зураг № 14 Уурхайн шүүрлийн уснаас дээж авч буй байдал*

*Газрын хэвлийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт*

**ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЦАГААН ЧУЛУУТ  
ХООЛОЙН ДУНД ХЭСЭГ”-ЫН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

*Хүснэгт 4 Газрын хэвлийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт*

№	Төлөвлөгөө	Хариуцах эзэн	Биелэлт
1.	Газар эзэмших гэрээгээ сумын ЗД-тай байгуулах, төлбөрөө төлөх	Компанийн захирал	Газар эзэмших гэрээгээ сумын засаг даргатайгаа байгуулан төлбөрөө төлсөн.
2.	Шимт хөрсний нөөц бий болгоход стандартын дагуу овоолж, ургамалжуулан хадгалах	Уулын мастер	Шимт хөрсийг стандартын дагуу овоолго үүсгэн хадгалж байна. Олон жил хадгалахгүй учир ургамалжуулах шаардлагагүй гэж үзсэн.
3.	Засварын газраас өөр газарт тос масло асгарсан тохиолдолд асгарсан хэсгийг саармагжуулах	Уурхайн дарга	Засварын талбайгаас өөр газарт тос масло солих ажлыг хориглосон. Засварын талбайн хөрсийг “SGS”-ын хөрсний хүнд металлын шинжилгээнд өгсөн. Шинжилгээний дүн стандарт хэмжээнд байна.



*Зураг № 15 Шимт хөрснөөс дээж авч буй байдал*

ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЦАГААН ЧУЛУУТ  
ХООЛОЙН ДУНД ХЭСЭГ”-ЫН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



*Зураг № 16 ШТС талбай*



*Зураг № 17 ШТС-ын талбайгаас хөрсний дээж авч буй байдал*

ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЦАГААН ЧУЛУУТ  
ХООЛОЙН ДУНД ХЭСЭГ”-ЫН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



*Зураг № 18 Засварын талбай*



*Зураг № 19 Засварын талбайгаас хөрсний дээж авч буй байдал*

*3.2. Ургамал, амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах аргууд*

*Хүснэгт 5 Ургамал амьтны сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт*

<b>№</b>	<b>Хийгдэх ажил</b>	<b>Хариуцах эзэн</b>	<b>Биелэлт</b>
1.	Олон салаа зам гаргахгүй байх	Уурхайн дарга	Өглөө бүрийн ажлын зааварчилгаанд заавар өгдөг.
2.	Гал түймрийн аюулаас хамгаалж гал унтраах багаж хэрэгслийг хотхонд байрлуулна.	Уурхайн дарга	Галын аюулгүй байдлыг хангаж галын сараа байрлуулав. Мөн техник бүрийн галын аюулгүй байдлыг ханган ажиллаж байсан.
3.	Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж аливаа газар хөндөх үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө Газар хөндөх зөвшөөрөл авах, олгох, бүртгэл хөтлөх	Уурхайн дарга	Төлөвлөлтөөс өөр газар хөндөөгүй болно.



*Зураг № 20 Галын сарааг ШТС талбайд байршуулсан байдал, уурхайн техник бүрд галын аюулгүй байдлыг хангаж буй байдал*

#### 4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ


Уурхайн ашиглалтын ажил явагдаж байхад нөхөн сэргээлт буюу дүүргэлтийн ажлыг дотоод овоолгоор зэрэгцээ байдлаар хийдэг. Энэ нь нөхөн сэргээлтийн зардлыг багасгах болоод их хэмжээний гадаад овоолгыг үүсгэн, газрын эвдрэл үүсгэхгүй байх давуу талтай.

2025 оны эцсийн байдлаар нийт 3.72 га газар эвдрэлд өртөх ба 2025 онд 3.72 га талбайд дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт, 5 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажил хийхээр төлөвлөж 3.72га талбайдаа техникийн нөхөн сэргээлт, 8.3 га талбайдаа биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн сайдын А/742 тоот тушаал, 0000008 дугаартай Газрын хэвлийн нөхөн сэргээлт хийх мэргэжлийн байгууллагын эрх бүхий “Газарресурс”ХХК -тай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэв. “Газарресурс “ХХК-ийн нөхөн сэргээлтийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хавсралтаар оруулсан болно.

Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд орон нутагтайгаа тохиролцсоны дүнд орон нутагтаа 25сая төгрөг шилжүүлсэн. Баяндун сумын нийтийн эзэмшлийн гудамж талбайд ногоон байгууламж нэмэгдүүлэх ажлын хүрээнд мод тарих арчлах ажлыг орон нутаг зохион байгуулсан болно. Орон нутгийн санал бүхий албан тоотыг хавсралтаар оруулсан болно.

**ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЦАГААН ЧУЛУУТ  
ХООЛОЙН ДУНД ХЭСЭГ”-ЫН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**



Зураг № 21 Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн байршил



*Зураг № 22 Дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийж буй байдал*



*Зураг № 23 Техникийн нөхөн сэргээлт хийж буй байдал 2025*

**ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЦАГААН ЧУЛУУТ  
ХООЛОЙН ДУНД ХЭСЭГ”-ЫН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Биологийн нөхөн сэргээлтийн явцыг харуулав.



*Зураг № 24 Үрийн холимгоо бэлтгэх, трактороор үрслэгээний ажил хийж буй байдал*




*Зураг № 25 Биологийн нөхөн сэргээлтийн ургалт 2025.09.05*



*Зураг № 26 Биологийн нөхөн сэргээлтийн ургалт 2025.09.17*

**ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЦАГААН ЧУЛУУТ  
ХООЛОЙН ДУНД ХЭСЭГ”-ЫН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**



				"Хорг" ХХК	
Алб/гушаал	Овог нэр	Гүсэг	Огноо		
Уурхайн дарга:	Т.Эрдэнэсайхан			Дорнод аймгийн Баяндун сумын нутагт орших Цагаан чулуут хоолойн дунд хэсгийн алтны шороон орд	Хэлтэс
Геологч И:	Б.Алтансүх				Масштаб
Маркшейдер И:	М.Галхандэлгэ				М1:1500
					Хуудас 1
				Уурхайн биологийн нөхөн сэргээлтийн дэвсгэр зураг	Хуудас 1 Цагаан чулуут хоолой алтны шороон орд

Зураг № 27 Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай

## 5. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Хоту”ХХК нь дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Баяндун сумын засаг даргын өгсөн чиглэлийн дагуу тарвага нутагшуулах ажлыг төлөвлөөд байна. Хустайн нурууны байгалийн цогцолбор газраас 20 ш тарвага (*Marmota sibirica*)-г Дорнодын Баяндун сумын нутагт нутагшуулахаар төлөвлөж байна. Энэхүү ажлыг Амьтны мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Орон нутгийн хүсэлтийн дагуу дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд 25 сая төгрөгийг орон нутагт шилжүүлсэн. Мөн тарвага нутагшуулах ажлыг 2025 оны 07 сард зохион байгуулахаад мэргэжлийн байгууллагад хандсан боловч цаг хугацааны хувьд оройтсон байсан. Тиймээс тарвага нутагшуулах ажлыг 2026 онд зохион байгуулахаас өөр аргагүй болсон учир “Авралын эрэлд”ХХК-тай ажлын гэрээ байгуулан урьдчилгаа төлбөрөө төлөөд байна. Гэрээ болон төлбөр төлсөн баримтыг хавсралтаар оруулав.

## 6. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй.

## 7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны олборлолтын явцад ямар нэгэн түүх, соёлын дурсгалт зүйл олдоогүй болно.

## 8. ХИМИЙН БОДИС, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 онд осол эрсдэлгүй ажилласан байна. Хөдөлмөр аюулгүй байдлын сургалт, өдөр тутмын зааварчилгааг ХАБ хариуцсан мэргэжилтэн өгч байгаа билээ.

Мөн төсөл хэрэгжих шороон ордын ашиглалтын явцад химийн тэсэрч дэлбэрэх химийн бодис ашиглаагүй.

## 9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Үйл ажиллагааны явцад гарах ахуйн хог хаягдлыг Баяндун сумтай гэрээ байгуулан өөрсдийн машинаар тээвэрлэн хаясан. /Төлбөр төлсөн баримт хавсаргав/ Мөн байгальд шууд хаягдах хаягдлын хэмжээг багасгахын тулд эх үүсвэр дээр нь ялган ангилалт хийх хогийн савыг уурхайн хотхон байрлуулан, ялган ангилалт хийж, ажилчдад хог хаягдлыг хэрхэн ялган ангилах талаар сургалт зохион байгуулсан. Техникээс гарах хаягдал тосыг “Түмэн эгшиг”ХХК-тай гэрээ байгуулан нийлүүлэн ажиллаж байна. Гэрээ болон тусгай зөвшөөрлийг хавсралтаар оруулав.

*Хүснэгт 6 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө болон биелэлт*

№	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Биелэлт
1.	Хаягдлаас гарах дахин ашиглагдах түүхий эдийг ялгах, тушаах	Уурхайн дарга	Хог хаягдлыг дахин ашиглагдах болон аюултай гэж ангилан хурааж байна. Ангилан ялгасан хог хаягдлыг эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан нийлүүлж байна. Хог хаягдлын ангилсан зураг оруулав.
2.	Хог хаягдлын гэрээгээ Баяндун сумтай байгуулах Хог хаягдлын төлбөрөө төлнө.	Уурхайн захирал	Төлбөр төлсөн баримт, хог хаягдлын гэрээ, Сумын байгаль хамгаалагчдын тодорхойлолтыг тус тус хавсаргав.

**ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЦАГААН ЧУЛУУТ  
ХООЛОЙН ДУНД ХЭСЭГ”-ЫН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

3.	<p>Ахуйн шингэн болон хатуу хог хаягдлын цэг засвар хийх, хатуу хог хаягдлыг доторлох, зарим хаягдлыг нэгдсэн журмаар сумын хог хаягдлын цэгт хаях.</p> <p>Хаягдлаас гарах дахин ашиглагдах түүхий эдийг ялган тушаах</p> <p>Хог хаягдал, ялган ангилалт, түүний үр ашгийн талаар сургалт, мэдлэг олгох</p>	Уурхайн дарга	<p>Хог хаягдлын цэгийг хөрс бохирдохоос хамгаалж цементлэн тохижуулсан.</p> <p>Ахуйн хог хаягдлаа тухай бүр тээвэрлэн сумын хогийн цэгт төвлөрүүлж байсан.</p> <p>Зураг оруулав.</p>
4.	<p>Ахуйн бохир ариутгах, халдваргүйжүүлэх, задлах бодис худалдаж авах зардал</p>	Уурхайн захирал	<p>50-60 хүний хүчин чадал бүхий ахуйн бохир цэвэрлэх байгууламж суурилуулсан.</p>
5.	<p>Уурхайн техникүүдийн засварын цех, мөн уурхайн техникт ашигласан, сольсон тос маслог сар бүр тусгайлсан саванд хуримтлуулна. Хаягдал техникийн тос, масло хуримтлуулах /сар болгон аюултай хаягдлаа 1 удаа гэрээ хийсэн газарт нийлүүлэх зайлуулах/</p>	Уурхайн дарга	<p>“Түмэн эгшиг”ХХК-тай гэрээний дагуу ажиллаж байна. Хаягдал тос 1000л, тостой арчих материал агаар шүүгч 157ш, тосны шүүр, түлшний шүүр 340ш, хаягдал акумулятор 30ш, хаягдал дугуй 100ш-г Төв аймгийн Сэргэлэн суманд байрлах “Химийн хорт болон аюултай бодисын сав баглаа боодлыг дахин боловсруулах эко үйлдвэр”-т тушааж акт үйлдэв.</p>

**ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЦАГААН ЧУЛУУТ  
ХООЛОЙН ДУНД ХЭСЭГ”-ЫН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**



*Зураг № 28 Хог хаягдлаа ангилан ялгах тусгай талбай байгуулсан байдал*



*Зураг № 29 Хаягдал тосыг цуглуулж буй байдал*



*Зураг № 30 Сумын хогийн цэгт ахуйн хог хаягдлаа хаяж буй байдал*

Ажилчдын шингэн хог хаягдлыг ариутгах зорилгоор 50-60 хүний хүчин чадалтай ахуйн бохир цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулсан.



*Зураг № 31 Ахуйн бохир цэвэрлэх байгууламж суурьлуулж байгаа байдал*



*Зураг № 32 Ажилчдад зориулсан халуун ус, дотор нойл бүхий ариун цэврийн газрын тохижилт*

## 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тус оны 5 дугаар сард Байгаль орчны зөвлөх үйлчилгээний эрх бүхий “Газарчандмань”ХХК-аар хийлгүүлсэн.

Тус хөтөлбөрийн хүрээнд хөрс, уснаас дээж авч итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлж мөн агаар дахь тоосжилтын хэмжээ болон дуу, чимээ зэрэг үзүүлэлтүүдийн хэмжилтийг хийсэн. Агаарын чанарын стандарт MNS 4585:2025 шаардлагад тоосонцрын агууламж /POM 2.5, POM 10/, хүхэрлэг хий, азотын давхар исэл зэрэг агаарын чанарын үзүүлэлтүүдийг бидний хэмжилт хийсэн уурхайн ухааш, тээвэрлэлтийн зам зэрэгт хүлцэх хэмжээнээс давсан үзүүлэлт байхгүй байна.

Уурхайн технологийн ус болох цэвэр болон бохирын нуурын усыг MNS 4943:2015 стандартаар үзүүлсэн. Тус шинжилгээний үр дүнгээр цэвэр болон бохир нуурын ус стандарт хэмжээнд байна.

Уурхайн ундны усанд ундны усны стандартад нийцэж байгаа эсэх, мөн бактерлогийн шинжилгээ хийлгэсэн болно. Тус шинжилгээний үр дүнд Ундны усанд Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 900: 2005 стандартын хэмжээнээс давсан үзүүлэлт илрээгүй болно.

Уурхайн засварын газар, ШТС-ын газрын хөрсийг “SGS”ХХК-ын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн бөгөөд хүнд металлын 33 элементийг үзүүлж хүлцэх агууламжтай харьцуулсан бөгөөд хүлцэх хэмжээнээс давсан үзүүлэлт гараагүй болно.

Шимт хөрс хадгалсан овоолгоос дээж авч шинжлүүлсэн бөгөөд хөрс нь шүлтлэг урвалын орчинтой, карбонатгүй, ялзмагийн агууламжаар дунд зэрэг, цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор болон калийн хангамжаар дунд зэрэг, механик бүрэлдэхүүн элсэнцэр. Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин дундаж гарсан байна.

Хүснэгт 7 Орчны хяналт шинжилгээний хүрээнд хийгдсэн ажил

Хяналт шинжилгээний дээж	Хяналт шинжилгээний үзүүлэлт	2025 оны хяналт шинжилгээний хэлбэр, зардал	Хяналт шинжилгээ явуулах хугацаа	Хяналт шинжилгээ явуулах байршил	Хяналт шинжилгээ хийх багаж, холбогдох стандарт
Агаар	Агаар орчны бохирдол агаар дахь тоосны агууламж, NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> CO -ын агууламж, дуу чимээ	Агаарын шинжилгээний 2 цэгт 2 удаа хэмжилт хийлгэнэ.	2025.05 сард	Уурхайн карьер, Уурхайн зам, Ажилчдын хотхон	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Агаарын чанар-хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 6063: 2010, Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585: 2016
Ус	Ажилчдын унд ахуйд ашигладаг усыг бактериологи болон ундны усны ерөнхий шаардлага, цэврийн болон бохирын нуурын усыг хүнд металлын шинжилгээнд өгөх	Унд ахуйн ус Бактериологи Усны химийн ерөнхий шинжилгээ Цэврийн болон бохирын нуур Хүнд металл	2025.05 сард	Унд ахуйн ус, цэвэр болон бохирын нуур,	Усны тухай хууль, Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус, Ерөнхий шаардлага MNS 4943:2015, Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900: 2018, Байгаль орчны аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2018 оны 04 сарын 05 өдрийн А82/128 тоот тушаалын хавсралт. Ахуйн хаягдал ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журам
Хөрс	Хөрсний агрохими, нийт азот, хөдөлгөөнт фосфор, солилцох кали, карбонат, Хүнд металл(Cr, Pb, Cd, Ni, Zn), бактери	шимт хөрсний овоолго, засварын газар, ШТС орчим	2025.05 сард	шимт хөрсний овоолго, засварын газар, ШТС орчим	MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр. төрөл MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох MNS2305-94 Дээж авах. савлах. тээвэрлэх. хадгалах журам MNS(ISO) 4814:1999. Атом Шингээлтийн Спектрометрээр шинжилгээ хийх

## 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уурхайн үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга хариуцаж ажилласан бөгөөд 2025 онд аваар осолгүй хариуцлагатай ажилласан болно.

*Хүснэгт 8 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө болон биелэлт*

№	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Биелэлт
	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Компанийн захирал Байгаль орчны мэргжилтэн	Захирлын тушаал бүхий дотоод журам гарган мөрдлөг болгон үйл ажиллагаандаа нэвтрүүлээд байна.
	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОУАӨЯ болон сумын ЗДТГ-т хүргэн өгч байх		Дорнод аймгийн БОГазарт 11 сарын 01 багтаан хүргүүлэв.
	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтэд хяналт тавих		Байгаль орчны ажлыг хэрэгжүүлэхтэй холбоотой гэрээ байгуулах, төлбөр төлөх ажлыг цаг алдахгүй гүйцэтгэж байсан.

## 12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ СУМ БАГИЙН ИРГЭДЭД ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХУВААРЬ

Иргэдийн хуралд байгаль орчныг хамгаалах болон нөхөнс сэргээлт, нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн ажлуудаа иргэдэд нээлттэй танилцуулсан. Нийгмийн хариуцлагын хүрээнд нийт 177,8 сая төгрөгний ажил гүйцэтгээд байна.

**ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЦАГААН ЧУЛУУТ  
ХООЛОЙН ДУНД ХЭСЭГ”-ЫН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**



*Зураг № 33 Иргэдэд хийсэн ажлаа танилцуулж буй байдал*

*Хүснэгт 9 Нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн ажлын жагсаалт*

№	Орон нутгийн хандив тусламж	Төгрөг
1	Баяндун сумын 100 жилийн ой болон ногоон байгууламж,цэцэрлэгт хүрээлэн байгуулах	100,000,000
2	5 сар Баяндун сумын төвийн зам засварын болон хогийн цэгийг шинэчлэх ажил	33,750,000
3	6 сар Баяндун сумын Үлийн давааны зам засварын ажил	18,687,500
4	Баяндун сумын Ахмадын хорооны ажил	234,350
5	“Дун хайрханы тахилга” мөнгөн хандив	3,000,000
6	Тоонотын баяр	15,000,000
7	Наадмын талбайн зам усалгаа	2,150,000
8	Цэцэрлэгийн 60 жилийн ой	5,000,000
9	Сургуулийн автобус	
		<b>177,821,850</b>

*Хүснэгт 10 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө*

№	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Биелэлт
1	Уурхайн үйл ажиллагаатай сум орон нутгийн иргэд, ЗДТГ-ын мэргэжилтэн, холбогдох мэргэжилтнүүдийг газар дээр нь танилцуулна.	Компанийн захирал Байгаль орчны мэргэжилтэн	Баяндун сумын тайлан хэлэлцүүлэх хуралд компанийн үйл ажиллагаа, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа, нөхөн сэргээлт, нийгмийн хариуцлагын хүрээнд хийж буй ажлаа танилцуулан хуралд оролцсон.

**ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЦАГААН ЧУЛУУТ  
ХООЛОЙН ДУНД ХЭСЭГ”-ЫН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2	Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулан аймгийн байгаль орчны албанд хүргүүлнэ.		Дорнод аймгийн БОГазарт 11 сарын 01 багтаан хүргүүлэв.
3	Нөхөн сэргээлтийг танилцуулж улсын комисст хүлээлгэн өгөх.		Тайлан хүлээн авсны дараа нөхөн сэргээлтийн улсын комисст хүлээлгэн өгч акт үйлдсэн.

### 13. ДҮГНЭЛТ

Уурхайн ашиглалтын ажил явагдаж байхад нөхөн сэргээлт буюу дүүргэлтийн ажлыг дотоод овоолгоор зэрэгцээ байдлаар хийдэг. Энэ нь нөхөн сэргээлтийн зардлыг багасгах болоод их хэмжээний гадаад овоолгыг үүсгэн, газрын эвдрэл үүсгэхгүй байх давуу талтай.

2025 оны эцсийн байдлаар нийт 3.72 га газар эвдрэлд өртөх ба 2025 онд 3.72 га талбайд дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт, 5 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажил хийхээр төлөвлөж 3.72га талбайдаа техникийн нөхөн сэргээлт, 8.3 га талбайдаа биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн сайдын А/742 тоот тушаал, 0000008 дугаартай Газрын хэвлийн нөхөн сэргээлт хийх мэргэжлийн байгууллагын эрх бүхий “Газарресурс”ХХК-тай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэв.

Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд төлөвлөсөн тарвага нутагшуулах ажлыг тухай оны 3 сараас эхлэн мэргэжлийн байгууллагын төлөвлөгөөнд оруулах шаардлагатай байдаг. Энэ ажлыг гүйцэтгэхэд цаг хугацааны хувьд бид хожимдсон байсан.

Орон нутгийн хүсэлтийн дагуу дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд 25 сая төгрөгийг орон нутагт шилжүүлсэн. Мөн тарвага нутагшуулах ажлыг 2025 оны 07 сард зохион байгуулахаад мэргэжлийн байгууллагад хандсан боловч цаг хугацааны хувьд оройтсон байсан. Тиймээс тарвага нутагшуулах ажлыг 2026 онд зохион байгуулахаас өөр аргагүй болсон учир “Авралын эрэлд”ХХК-тай ажлын гэрээ байгуулан урьдчилгаа төлбөрөө төлөөд байна.

Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд орон нутагтайгаа тохиролцсоны дүнд орон нутагтаа 25сая төгрөг шилжүүлсэн. Баяндун сумын нийтийн эзэмшлийн гудамж талбайд ногоон байгууламж нэмэгдүүлэх ажлын хүрээнд мод тарих арчлах ажлыг орон нутаг зохион байгуулсан болно.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тус оны 5 дугаар сард Байгаль орчны зөвлөх үйлчилгээний эрх бүхий “Газарчандмань”ХХК-аар хийлгүүлсэн.

Тус хөтөлбөрийн хүрээнд хөрс, уснаас дээж авч итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлж мөн агаар дахь тоосжилтын хэмжээ болон дуу, чимээ зэрэг үзүүлэлтүүдийн хэмжилтийг хийсэн. Агаарын чанарын стандарт MNS 4585:2025 шаардлагад тоосонцрын агууламж /POM 2.5, POM 10/, хүхэрлэг хий, азотын давхар исэл зэрэг агаарын чанарын үзүүлэлтүүдийг бидний хэмжилт хийсэн уурхайн ухааш, тээвэрлэлтийн зам зэрэгт хүлцэх хэмжээнээс давсан үзүүлэлт байхгүй байна.

Уурхайн технологийн ус болох цэвэр болон бохирын нуурын усыг MNS 4943:2015 стандартаар үзүүлсэн. Тус шинжилгээний үр дүнгээр цэвэр болон бохир нуурын ус стандарт хэмжээнд байна.

Уурхайн ундны усанд ундны усны стандартад нийцэж байгаа эсэх, мөн бактерлогийн шинжилгээ хийлгэсэн болно. Тус шинжилгээний үр дүнд Ундны усанд Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 900: 2005 стандартын хэмжээнээс давсан үзүүлэлт илрээгүй болно.

